

## ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019.10.14

№27

Дархан

Аймгийн Засаг даргын өглөөний шуурхай хурал 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 08.00 цагт эхлэв. Хурлыг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд удирдаж хуралд оролцвол зохих 18 гишүүнээс 15 албан тушаалтан оролцож ирц 83.3 хувьтай байв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайлан

### ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

ХЗДХ-аас хэдэн удаа ямар зөвлөмж ирсэн бэ? Хэрэгжилт ямар байгаа вэ? /ХЭЗХ/

ЖДҮ-ээс зээл олгохоор төсөл шалгараад банк руу явсан. Зарим нь дэмжигдсэн. Зарим нь боломжгүй гэсэн хариу авсан юм байна. Жагсаалтаар дээшлэх ёстой. Дараа дараагийн аж ахуйн нэгжүүдийг оруулаач. /ХОХБТХ/

60 дугаар байраа яах вэ гэдгээ энэ 7 хоногт шийдвэрлэе. /ХЭЗХ, ОНӨГ/

Хотын өдрөөр нээлт хийх ажлуудыг судлаж хуваарьт оруулъя. /ХОХБТХ/

Хөрөнгө оруулалтын ажлуудаа шахаж явъя. Хугацаа бага үлдсэн. /ХОХБТХ/

Хөрөнгө оруулалтын хурал дээр афтар компаниудтай уулзалт хиймээр байна. /ХОХБТХ/

Шарын голын эмнэлэг 23 сая, Салхитын 10 сая, брак буулгалтын мөнгө, нөөцийн өвсний мөнгө гээд өрнүүдээ сайн тэмдэглэж яваарай. /ХОХБТХ/

Хотын өдрийн арга хэмжээний оролцоог хангаарай. /Бүгд/

Орхон сум хөрөнгө оруулалтын ажил хангалтгүй байна. ГХБХБГ-аас хүн очон уу? Газар шорооны ажил эхэлсэн үү? Дээвэр дууссан уу? /Орхон сум/

Ажлаа шахая. Өвөлжилтийн бэлтгэл дутуугаа анхааръя. /ЗАА/

35,36 дугаар брак бүрэн буусан уу? Нэг байшин 9.9 сая уу? Нийт хэдэн төгрөгний өр байгаа вэ? /ОНӨГ/

ОБГ-ын мөнгийг өгсөн. Таны ярьсан 30 сая, 10 сая төгрөгний гэрээ манай дээр яригдаагүй. Бид Засаг даргатай суугаад 140 гаруй сая төгрөгийг тодотгохоор тохирсон.

710-А гэсэн байрны асуудал байна. Иргэний өмч шүү. Яагаад нэг байгууллага 2 өөр бичиг өгдөг юм бэ? 710 гэсэн бичиг улсын бүртгэлд өгсөн. ХОХБТХ-т 710-А гэж өгсөн байгаа юм. Одоо үүнийг шийдвэрлэе. Иргэд хохирох асуудал гаргаж болох уу?

Төмөрлөгийн зуухыг аваагүй байна. Төмөрлөгт Актлах зуух байгаа. Үүнийг Хонгорт өгөх. /ЗАА/

Малчдаа оруулаад ирсэн. Тариа хураагаагүй байдаг. Тариа руу мал орох вийдээ. УРьдчилж малчдад мэдээлэл, сэрэмжлүүлэг өг. /Хонгор сум/

Төрийн сангийн хэлтэс гүйлгээ битгий саатуулаарай. Байгаль цаг ууртай уралдаад яаралтай хийгдэж байгаа ажил бөайгаа шүү. Замын ажил, цэцэрлэг, замын өргөтгөлүүд гэх мэт шуурхай ажлууд байгаа. Гүйлгээг нь журмын дагуу цаг алдалгүй олгоорой. /СТСХ/

БТСГ-ын гадна шугамыг шуурхай шийдье. /ЗАА/

Орлогын төлөвлөгөөг анхааръя. /СТСХ/

НААҮГ-ыг яах вэ? Ажлын хэсэг байгаа, хуралдуулъя. /СТСХ, ЗАА/

Хотын өдрийн өмнө бүх нийтийн цэвэрлэгээг хийх үү? Сум, СӨХ, байгууллагууддаа ханд. Амралтын өдрийг хүлээлтгүй. Хотын төв 2 дугаар төв рүү орсон замыг үзээрэй. Хотын өдрийг угтаж зам талбайгаа цэцвэрлэ. Аж ахуйн нэгжүүд гадна талаа цэвэрлэх /ЗАА/

Сэтгүүл, иргэдээс санал авах хэрэгтэй. 70371212 утсаар дан ганц биш сум, багаар нь саналыг нь авах. Хотын өдрийг угтаад ОНӨГ, ЗА, ХО, Сумдууд ярилцлагууд авах. Салбар салбараар нь ярилцлага авах. /МТА/

ЗД-ын хөтөлбөрт цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлыг оруулсан. Судалгаа хийж, хөрөнгө мөнгө тавиарай. Дүйцүүлэх цэвэрлэгээ үйлчилгээнд оруулах /Цэргийн штаб/

Хонгор сумын 10 цэрэг байгаа. Орхонд бас байгаа

56 байгаад 31 болсон байна. Засаг даргад төсвийн асуудлыг тавих юм байна.

Мал бүхий иргэд, гэсэн 2 асуудал байгаа. Ирэх жилийн төсөвт суулгах асуудал байгаа. 99 бол энэ жил, 200 бол өнгөрсөн

Хотын баярын арга хэмжээг ТЗУХ хариуцна шүү. Алдаа гарвал хариуцлагыг удирдлагын хэлтэстэй ярина шүү.

Засаг даргын өгсөн үүргийг чанартай гаргах

Гэр хороололд гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх талаар Засаг даргаас үүрэг өгсөн. Гэтэл Австрийн гэрэлтүүлэг гээд бичээд байх юм. Түүнтэй хамаагүй шүү дээ.

Ганбаяр ажилдаа ирээгүй. Аижл хэвийн явагдаж байгаа гэж тайлагнасан байна. 20 оны төсөвт суулгасан гэж юу яриад байгаа юм бэ? Төсөв батлаагүй шүү дээ. Хэн батлаад байгаа юм бэ? Биелэлтүүдээ бодож тайлагнах хэрэгтэй.

Хурал 9 цаг 40 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС